



“ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ  
ТӨВ” ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Д.БЯМБАСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.05.03 № 03/7699  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахгаас гадна авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид гаргахгүй байх таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор авлигаас ангид байлгах, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй хүргэх, нийтийн албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх чиглэлд анхааран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр баталсан Удирдамж, төлөвлөгөөний дагуу “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-нд “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журам”-ын хэрэгжилтэд дүгнэлт хийх, Төвийн 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлттэй танилцах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг асуудлаар 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 20-ны хооронд ажиллаа.


Ажиллах явцад “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журам”-ын хэрэгжилт хангалтгүй, авлига ашиг сонирхлын зөрчил гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзэхээр байх тул Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасны дагуу албан “Зөвлөмж”-ийг хавсралтаар хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2023 оны 08 дугаар сарын 15-ны дотор манайд ирүүлнэ үү.

Жич: Хавсралт... хуудас.

Хувийг, Эрчим хүчний яаманд.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР




З.БААСАННЯМ

142303007800

Авлигатай тэмцэх газрын  
2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн ....  
03/ дугаар албан бичгийн хавсралт  
17699

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ



**Зөвлөмж 1. “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК нь Эрчим хүчний тухай хууль тогтоомжид нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах.**

Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар тогтоолоор “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК болгон өөрчлөн зохион байгуулж, тогтоолын хавсралтаар батлагдсан “Дүрэм”-ийн 1.3-т “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр болон энэ дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна” гэж зохицуулсан байхад хүчин төгөлдөр бус дүрэм, журмыг шинэчлэлгүйгээр үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:

1. Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/43 дугаартай тушаалын хавсралтаар “Албан томилолтын журам”-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалаар тогтоосон “жишиг норм”, Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаартай тушаалаар “албан томилолтын зардлын тариф шинэчлэн баталсан”-тай уялдуулан шинэчлэн боловсруулж батлах;

2. Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын 2015 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Б/61 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан “Нууцын тухай журам”-ыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 232 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ын дагуу шинэчлэн боловсруулж батлах;

3. Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Захирлын зөвлөлийн ажиллах журам”-ыг “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн дүрмийн 9.7 дугаар зүйлд “Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална” гэж заасны дагуу ТӨХХК-ийн захирлын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хэлэлцсэн боловч Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Захирлын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан шийдвэр гаргаагүй байх тул зохих ёсоор батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;

4. Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/03 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, ажлын зардлын хувь хэмжээ тогтоох тухай” журмыг Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, Эрчим хүчний сайдын 2015 оны 188 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журам”-ын шинэчлэн батлагдсан журамд тус тус нийцүүлж шинэчлэн батлах.



**Зөвлөмж 2. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг сайжруулан, бодитой ажил, арга хэмжээг удирдлагын зүгээс авч хэрэгжүүлэх, тайлагнах.**

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр баталж, хэрэгжилтийг 1 дүгээр улирлын байдлаар гаргуулан авч, үнэлж дүгнэхэд **43.33 хувьтай** “хэрэгжих шатанд” хэрэгжилттэй байна. Нийт 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөөнөөс хэрэгжих шатандаа 5 (70 хувь), хэрэгжилт хангалтгүй 10 (30 хувь) байна;

Төлөвлөгөөний хэрэгжилт бүрийг дүгнэн үзэхэд хангалттай түвшинд хэрэгжээгүй ажлуудын хувьд “арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна” гэсэн тайлан 8 ажил, арга хэмжээний хүрээнд тайлагнасан;

Төлөвлөгөөний 3.1-т заасан “Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх” гэсэн ажил арга хэмжээг зөвхөн “Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл хуудсыг гэрээ байгуулахад бөглүүлэн гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна” гэсэн тайлбартайгаар хэрэгжүүлж байгаа нь учир дутагдалтай байна.

Төлөвлөгөөний 3.1-т заасан арга хэмжээ нь төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах хэдэн төрлийн ямар гэрээ хэлэлцээрт “авлигаас урьдчилан сэргийлэх” талаарх зүйл, заалтыг нэмж тусган өөрчлөлт оруулсан эсэхийг байгууллагыг төлөөлж оролцож байгаа албан тушаалтнаас зохих мэдэгдэл тайлбар гаргасан мэдээллийн хамт тайлагнахыг цаашид анхаарах.

**Зөвлөмж 3. Хуулиар олгогдоогүй эрхийг хэрэгжүүлэхгүй байх, үйлчилгээ авч буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа аливаа үйл ажиллагааг таслан зогсоох.**

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/06 дугаартай “эрчим хүчний нэгдсэн лабораторийн ажил үйлчилгээний нэгдсэн төрөл, үнэ тариф шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар “цахилгаан техникийн лабораторийн ажлын үнэлгээ”-г, 2 дугаар хавсралтаар “металл шинжилгээ, гагнуурын лабораторийн ажлын үнэлгээ”-г, 3 дугаар хавсралтаар “химийн лабораторийн ажлын үнэлгээ”-г тус тус баталсан байна.

Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно” мөн хуулийн 64.1-т “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална” гэж заасныг,

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 10 дугаартай тогтоолоор гүйцэтгэх захиралтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний 3.29-д “эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар, журам гаргана” гэж заасныг тус тус зөрчиж “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал хуулиар өөрт нь олгогдоогүй эрхийг эдэлж үнэ тариф тогтоон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас үндэслэлгүйгээр төлбөр, хураамж авч байна.